



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн туслалцааны төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 8,216,959.74 (найман сая хоёр зуун арван зургаан мянга есөн зуун тавин есөн төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 1 /нэг/ ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Т.Уранболорт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

3.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



0001034

Төрийн өмчийн бодлогого зохицуулалтын газрын  
 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн  
 дугаар тогтоолын хаворалт

Хууль зүйн туслалцааны төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

| Д/Д | Үндсэн хөрөнгийн нэр        | Нийт гүйлт (км) | Ашиглалта д орсон он | Балансын үнэ (төгрөг)   | Хууримтлагдсан эпэгдэл (төгрөг) | Үлдэгдэл ёртөг (төгрөг)   | Худалдах доод унэ (төгрөг) |
|-----|-----------------------------|-----------------|----------------------|---|---------------------------------|---------------------------|----------------------------|
| 1   | Тоёота надиа (sxn100029249) | 162014          | 1999                 | 8,216,959.74  | 8,216,959.74                    | -                         | 1,000,000.00               |
|     | Нийт дүн                    |                 |                      | 8,216,959.74<br>(найман сая хоёр зүүн арван зураган мянга есөн зүүн тавин есөн төгрөг далан дөрвөн мөнгө) |                                 | 1,000,000.00<br>(нэг сая) |                            |